

**ХҮН ЯАЖ ҮҮССЭН ТУХАЙ ТАЙЛБАНУУДАД ҮНЭЛГЭЭ
ӨГӨХӨД К.ЯСПЕРСИЙН “ТРАНСЦЕНДЕНЦИ”
ГЭДЭГ ФИЛОСОФИ БАРИМТЛАЛ
ХЭРХЭН ХОЛБОГДОХ НЬ**

Ц.Гомбосүрэн - МУИС, Философийн тэнхим, доктор (Sc.D.), профессор

Д.Энхжаргал - ИЗИС-ийн түүх, монгол судлалын тэнхим, докторант

Түлхүүр үг: Ч.Дарвины хувьслын онолын арга зүйн онцлог. Энэ онолд эсрэг шинжлэх ухааны мэдээ сэлт ба тайлбар. “Лемур хүний иргэншил” “Атлантын иргэншил”, И.Катюхины оккультив тайлбар.

Бидний энэ өгүүллийн зорилго нь хүний үүслийн тухай шинжлэх ухааны болон бусад төрлийн (түүний дотор оккультив болон эзотерик) мэдлэгт философийн үүднээс үнэлгээ өгөхөд германы экзистенциалист философич Карл Ясперс (1883-1969)-ийн боловсруулсан холбогдох баримтлал, үндэслэлүүд чухал ач холбогдолтойг авч үзэхэд оршиж байгаа болно. Үүний тулд эхлээд хүний үүслийг шинжлэх ухааны аргаар тайлбарлаж буй янз бүрийн мэдлэгийн, түүний дотор оккультив шинжлэх ухааны мэдлэгийн гол гол төлөөллийн агуулгыг товч авч үзье.

Нэг. Хүний үүслийн тухай Чарлз Дарвины хувьслын онол шүүмжлэгддэг байдал. Хүн яаж анх үүссэн түүхтэй вэ? гэдэгт найдвартай хариулт өгөх бололцоо шинжлэх ухаанд эдүгээ хүртэл бүрдээгүй байгаа билээ. Энэ нь асуудлыг бүрэн зөв тайлбарлахад чухал түүхийн мэдээ сэлт хангалттай олдохгүй байгаагаас шалтгаалдаг. Иймд уг асуудлыг тайлбарласан үр дүн, тухайлбал, хүн үүссэний шалтгааныг болон цаг хугацааг нь тогтоосон байдал өнөө үед олдсон археологи олдворын хүрэн дэх таамаглал байдаг. Тэгээд бас нэг биш, харин өөр өөр олон таамаглал байдаг.

Монголд марксизм ноёрхож ирсэн нөхцөлд, өөрөөр хэлбэл 1990-ээд оныг хүртэлх хугацааны олон арван жилд хүн үүссэн шалтгааныг Ч.Дарвины сургаалын үүднээс тайлбарладаг байв. Энэ нь Ф.Энгельсийн “Мич хүн болоход хөдөлмөрийн роль” гэдэг дуусгаж амжаагүй бүтээлийн агуулгад нийцүүлдэг үйл ажиллагаа байлаа. Зүйлийн тухай Ч.Дарвины сургаал бол хүний үүслийн шалтгааныг зөв тайлбарладаг ганц сургаал мөн гэдэг үзэл эдүгээ ч гэсэн манайд олон хүний хувьд хэвээрээ буй гэж болно. Дашрамд дурдахад Ч.Дарвины боловсруулсан хувьслын тухай үзэл санааг христос шашны зарим онолч хүртэл арга зүйгээ болгон сурталчилж иржээ. Энд францын философич, ламтан Тейяр де Шарденийг онцлох шаардлага байдаг. Тэрээр орчлонгийн хувьсал нь амьдралын угтвар, амьдрал, сэтгэлгээ, дээд амьдрал гэдэг шаталсан олон давхрааг дамжин дэвшиж ирсэн бөгөөд тэдгээр давхраа дотроос зөвхөн хүн ганцаараа “үүссэн хугацаагаараа сүүлчийн, хамгийн тэнхээлэг, хамгийн олон талт, хамгийн солонголог, олон өнгө бүхий байдаг”¹ гэж бичсэн байдаг. Гэхдээ ерөнхийдөө бол христос шашны онолчид хүн үүссэн шалтгааны талаархи Ч.Дарвины дэвшүүлсэн хувьслын үзлийг няцаах ажиллагаа явуулдаг юм.

Хүн хэрхэн үүссэн тухай Ч.Дарвины хувьслын онолыг шашин ба шашны философи төдийгүй шинжлэх ухааны олон тайлбар бас үгүйсгэж байдаг. Энд хоёр том баримт дурдъя. “Нэгдүгээрт хүн үүссэн шалтгааны тухай хувьслын үзлийг эргэлзэхэд төдийгүй эрс үгүйсгэхэд хүргэсэн археологийн гоц чухал олдвор XIX зуунаас хойш арвин гарах болсон байна. Тэдгээр олдворын заримд анхаарал хандуулах нь бидний энэ удаагийн зорилт мөн.

¹ Пьер Тейяр де Шарден. Феномен человека. М., 1987, с.179

Үүний тулд нэн түрүүнд судлаач Г.Армаа өөрийн зарим бүтээлд нэгтгэн тоочсон буй түүхэн олдворуудын заримыг сонгон дурдахыг зүйтэй гэж үзлээ. Үүнд¹:

- 1891 онд С.У.Калп гэгч америк эзэгтэй түлшний нүүрсээ хагалж байтал дотроос нь алтан гинж олдсон аж. Гэтэл газарт чулуун нүүрс бараг 300 сая жилийн өмнө бүрэлдэж ирсэн байдаг гэнэ. Шинжлэх ухааны судалгаагаар тэр үед манай дэлхийд ухаант хүн байтугай сармагчин төрөлт ч үүсээгүй байсан аж.

- 1928 онд Оклахама мужийн Хиверен хэмээх уурхайн ажилчид дэлбэлсэн нүүрсээ цуглуулж яваад 100 метрийн гүнд хэд хэдэн бетонон гулдмай, бас тийм дөрвөлжин гулдмайгаар босгосон ханатай тааралдсан байна. Уг нүүрсний уурхайн давхрага 280 сая жилийн настай байжээ.

- 1868 онд Огайо мужийн Хаммондвелле уурхайн ажилчид занар чулуугаар хийсэн мөн дээрхийн адил хана олсон аж. Ханын гадаргуу дээр эртний бичээс тод хэвээрээ үлджээ. Иймэрхүү олдворууд бүхий давхаргууд гол төлөв 100 метрээс илүү гүнд байж, давхаргын нас гол төлөв 600 сая жилд хүрдэг байна.

- 1844 онд Шотландын Нингуди хэмээх чулуу олборлох газарт элсэрхэг чулуунд зоогдсон төмөр хадаас олджээ. Элсэрхэг чулууны нас 400 сая жил байсан аж.

- 1983 онд Туркмений Кугинтаг уул хавьд 43 хүний хөлний размерийн мөр байхыг эрдэмтэд илрүүлжээ. Тэрхүү мөрний нас 150 сая жил гаруй бөгөөд Юрийн үс, үлэг гурвэлийн цэцэглэж байсан цаг юм.

- Хувьслын онолын үүднээс бол хүн дүрст бичний (гоминидийн) дээд өвөг нь неандерталь хүн мөн. Гэтэл германы хэсэг эрдэмтэд 1997 онд неандерталь хүний чулуужсан ясанд ДНХ-ийн шинжилгээ хийгээд түүнийг өнөөгийн хүний өвөг биш болохыг тогтоожээ.

Хоёрдугаарт, “Өнөөдөр” сонины 2010 оны 3 дугаар сарын 26-ны дугаарт бичсэнээр герман, орос, америкийн эрдэмтэд Алтайн хязгаараас хүүхдийн хурууны яс олсон нь неандерталь хүнийх ч биш, орчин үеийн хүнийх ч биш болох нь тогтоогджээ. 40000 жилийн өмнө амьдарч байсан гэж тогтоогдож буй энэ хүн неандерталь болон орчин үеийн хүний өвгөөс сая жилийн өмнө салсан бололтой гэж судлаачид үзэж байна. Энэ мэт баримт нь орчин үеийн хүн бол мичнээс үүсээгүй гэдэг дүгнэлтэнд олон олон судлаачийг хүргэж иржээ.

Хоёр. Хүний үүслийн тухай оккультив шинжлэх ухааны тайлбар. Мич бол хөдөлмөр зэрэг нийгмийн зүйлсийг үүсгэн сайжруулж ирснийхээ үр дүнд аажмаар хүн болж хувирсан тухай ялангуяа диалектик материализм XIX зууны сүүлийн хагасаас хойш хүчтэй сурталчилдаг болж, ингэхдээ Дарвины боловсруулсан зүйлийн онолыг үндэслэгээ болгодгийг эдүгээ шинжлэх ухааны үүднээс няцаах зорилтыг эрдэмтэд шинжлэх ухааны үүднээс дэвшүүлдэг болсныг бид өмнө дурдлаа.

Үүний зэрэгцээ шинжлэх ухаанаас давсан тийм сэтгэлгээний аргаар, түүний дотор оккультив шинжлэх ухаан (өөрөөр хэлбэл орчлон ертөнцөд төдийгүй бодгаль хүмүүст зөвхөн гэгээнтнүүд болон бясалгалын аргаар увидасын чадвар эзэмшсэн хүмүүс илрүүлж чадах тийм далд хүч байдаг гэгч үзлийн зарим элементийг шинжлэх ухааны үүднээс үндэслэдэг мэдлэг), бас спиритуалист (өөрөөр хэлбэл бодит байдлын анхдагч үндэс нь материаллаг биш, харин биегүй субстанци мөн гэдэг), эзотерик (өөрөөр хэлбэл хүн төрөлхтний амьдрал гүн нууц уг чанартай хэмээгч) зэрэг мэдлэгийн үүднээс хүний үүслийг дарвинизм, хувьслын онолд эсрэг агуулгаар тайлбарладаг янз бүрийн сургаал XX зууны сүүлийн хэдэн арван жилээс хүчтэй гарч ирэх болов.

¹ Энэ тухай: Г.Армаа. Хүний үүсэл. I. Дэлхий дахин. УБ., 2008, 135-138 дахь талд үзнэ үү.

Тэдгээрийн нэн чухал төлөөлөл болгож оросын нүдний гарамгай эмч, том судлаач гэдгээрээ дэлхий дахинаа эдүгээ алдаршаад байгаа Эрнст Рифгатович Мулдашевийн сурталчидаг оккультив шинжлэх ухааны тайлбарын агуулгыг энд илэрхийлье. Тэрээр уг тайлбартаа дэлхийн томоохон шашнуудын, түүний дотор буддын шашны холбогдох мэдээ сэлт, гэгээнтэн лам нарын өгүүлсэн нууцлаг мэдлэг зэргийг өөрийнхөө болон бусад судлаачийн шинжлэх ухааны эрэл хайгуулын үр дүнгээр зөвтгөсөн байдаг.

Э.Р.Мулдашев бол аливаа хүний нүдний эвэрлэгийн диаметр нь нүдний хэмжээнээс үл шалтгаалдаг тийм абсолют тогтмол буюу 10 ± 0.56 мм байдгийг олж тогтоон, улмаар үүндээ үндэслэн офтальмогеометрийн (нүдний дүрс зүйн) аргаар хүний нүүрний дүр төрхийг сэргээн босгосон; яс үндсийг нь зөв тогтоосон; өөр өөр арьстны офтальмогеометрийн ялгаа үлэмж байдаг ч ийм хэмжилтийн статистикийн дундаж нь төв; үндэстний нүд байдгийг илрүүлсэн; хүн төрөлхтөн Төвдөд анх үүсээд 4 үндсэн чиглэлд нүүдэллэн тархсан гэж үнэлгээ өгсөн судлаач мөн. Тэгээд төвд сүмүүдийн ханан дээр байдаг том нүд орчин үеийн хүнийх биш, харин далдыг мэдэгч, аугаа зөнч Нострадамусын номонд гардаг сөнөсөн атлантын иргэншлийн хүнийх юм байна гэсэн таамаглалыг тэрээр бас офтальмогеометрийн аргаараа хийжээ.

Тэгээд тэрээр уг таамаглалынхаа зөв эсэхийг тогтоохын тулд НҮБ-ийн Олон улсын шинжлэх ухааны академийн тэтгэлгээр олон улсын шинжлэх ухааны анги (экспедици) байгуулан удирдаж Төвд, Балба, Энэтхэг зэрэг Азийн орнуудад лам, хамба (свами) зэрэг олон аугаа бясалгагч нараас мэдээлэл цуглуулж, улмаар түүнээ гэгээнтнүүдийн бичиж үлдээсэн ном дахь ер бусын холбогдох мэдээтэй харьцуулан шинжилсэн олон жилийн нүсэр ажил гүйцэтгэсэн байна. Э.Р.Мулдашев Эрдэм шинжилгээний ийм шаргуу эрэл хайгуулаасаа “Хүн мичнээс төрөөгүй” гэдэг номдоо болон бусад бүтээлдээ олон чухал философи дүгнэлт хийсэн аж.

Орчин үеийн хүний үүслийн шалтгааны тухай Э.Р.Мулдашевийн таамаглалаас: бидний өвөг дээдэс болох лемурын ба атлантын иргэншлийн хүмүүс яаж үүссэн бэ? гэсэн лавшруулсан асуулт гарах бүрэн үндэстэй байдаг. Энд энэхүү судлаачийн тайлбараас дараахь зарим санааг нь онцлон дурдъя.

Газар дэлхийн амьдрал сүнсний нягтралаар үүссэн байна. Сүнс нягтрах үйл явц олон сая жил үргэлжилжээ. Анхны хүмүүс болбоос сүнс маягийн хүмүүс байжээ. “Тэд хана, хадыг нэвтэлж чаддаг, бодлоо хэлгүйгээр “дамжуулж” өөр хоорондоо харьцдаг байсан” гэнэ. Тэд маш сийрэг биетэй, бодит бие махбодийнхоо мэдээллийг нахиалах, хуваагдах замаар дамжуулах зориулалттай анхдагч генийн цогц байсан юм. Анхны хүмүүс сансрын долгионы хуулиар амьдардаг байсан ч газар дэлхийн хүмүүс гэхээсээ илүү Нөгөө Ертөнцийн элч төлөөлөгч мэт байлаа. “Сайн сайхан”, “хайр энэрэл”, “муу муухай” гэсэн ойлголт тэдний хувьд газар дэлхийн бодит асуудлаас хамаагүй чухал байжээ.

Хоёр дахь иргэншлийн (хий үзэгдэл маягийн) хүмүүс үндсэндээ нэгдүгээр иргэншлийн хүмүүс мэт амьдардаг байсан ч тэдний газар дэлхийн бодит бүрхүүл нь илүү нягт, бие махбодод уламжлуулан дамжуулах генийн цогцын аргачлал нь илүү төгс төгөлдөр байжээ.

Гурав дахь иргэншлийн хүмүүс (лемурчууд) нь илүү нягт, төгс төгөлдөр бодит биетэй, эхэн үедээ дөрвөн гар, хоёр нүүртэй аварга байсан ба хожуу үедээ, хоёр гар, нэг нүүртэй аврага биетэн болсон байна. Лемурын биед шингэсэн сүнс Нөгөө Ертөнцтэй холбоогоо бүрэн хадгалж байжээ. Тиймээс “SoHm”-ын буюу “Өөрсдөө боловсор” гэдэг зарчим үйлчилдэггүй байлаа. Лемур хүн нь илүү өндөр зохион байгуулалттай Нөгөө

Ертөнцийн хууль, зарчмаар амьдардаг байсан ч бодит ертөнц дэх идэвхтэй үйл ажиллагаа нь түүнийг энгийн ахуйн асуудалд ч мөн анхаардаг болгожээ.

Дөрөв дэх иргэншлийн хүмүүс (атлантчууд) Нөгөө Ертөнцтэй холбоогоо хадгалсаар байсан боловч газар дэлхийн энгийн ахуйн асуудал тэдэнд илүү ойр дотно болжээ. Нөгөө Ертөнцийн “сайн сайхан”, “хайр энэрэл”, “муу муухай” болон бусад ойлголт хойш ухарч, бодит бие махбодийн хэрэгцээ болох идэх, уух, унтах гэх мэт зүйлс илүү сонирхол татдаг болжээ.

Тав дахь иргэншлийн хүмүүс болох бид бол физик биеийнхээ боол юм. Нөгөө Ертөнцөөс “SoHm”-ын зарчмаар тусгаарлагдсан сүнс Нөгөө Ертөнцтэй холбох нэгтгэх үүргийг бус харин бие махбодийг оршин тогтнох үүргийг гүйцэтгэдэг болжээ. Нөгөө Ертөнцийн гол оршихуй болсон “сайн сайхан”, “хайр энэрэл”, “муу муухай” зэрэг үзэгдэл зөвхөн зөн совингийн шивнээ төдийгөөр илэрдэг болов. Зарим гэгээнтний бичсэнээр хожуу үеийн лемурчуудын үр хойч өнөө үед ч гэсэн байдаг нь Австралийн зарим хавтгай толгойт аборигенчүүд аж. Гэхдээ тэд (аборигенчүүд) бол өвөг дээдэс нь удам угсааны хувьд доройтож, зэрлэгшсэн тийм хойч үе гэнэ.

Холбогдох бүх эх сурвалжид бичсэнээр лемурчүүдийн хоёрдах үеийнхэн болох лемур-атлантчууд нь өвөг дээдэс лемурчууд болон хойч удам атлантчуудын аль алианаас нь илүү хөгжилтэй байсан бөгөөд тэдэнтэй харьцуулахад атлантчууд болон манай иргэншлийн хүмүүс ухаан суугаагүй балчир хүүхдүүд мэт юм. Зарим таамгаар лемур-атлантчууд нь одоо ч гэсэн нууцат Шамбалын орны гол төлөөлөгчид мөн. Тэдний (тарнийн хүчээр ажилладаг) нисдэг төхөөрөмжүүдийг эдүгээгийн хүмүүс оньсогот нисдэг таваг байдлаар заримдаа олж хардаг. Мөн олон эх сурвалжид бичсэнчлэн лемур-атлантчууд нь бүхий л нууцлаг далд зүйлсийг нэвт харах чадвартай төрдөг байжээ. Тэдний хараа нь хязгааргүй байсан учраар тэд эд зүйлсийн мөн чанарыг агшин зуурын төдий таньдаг байжээ. Тэдний хувьд орон зай, бодит зүйлсийн саад гэж байсангүй. Тиймээс тэд байгаль дэлхийн нууц хийгээд анхдагч мэргэн ухаанд гүнзгий нэвтэрсэн хүмүүс байв. Тэднийг Бурхан тэнгэрийн Хүүхдүүд гэдэг байжээ.

Лемур-атлантчууд нээлттэй билгийн нүдтэй байсан тул номлол, итгэл бишрэлд үндэслэсэн үзэл баримтлал боловсруулаад байх шаардлага тэдэнд байсангүй. Тэдний үе бол бурхан тэнгэр газар дэлхийгээр явж эгэл хүмүүстэй чөлөөтэй харьцдаг байсан балаг эртний “алтан зуун” байв. Дараа нь алтан зуун дуусч, бурхан тэнгэрүүд алслан одоо (өөрөөр хэлбэл харагдахгүй болж) орхисон аж. Лемур-атлантчууд нь төмөрлөг, ховор эрдэс бодис, хар чулуу, гантиг зэргийг ашиглан аварга том хот суурин барьдаг байжээ. Тэд 500 тонн хүртэл жинтэй чулуун цутгамлуудыг ашиглан барилга барьдаг байж. Английн Солюсберийн хөндий дэхь “Унжигч чулуунууд” болон Египетийн Сфинксийг лемур атлантчуудын бүтээл гэсэн таамаг байдаг.

Тэр үед дэлхий өөр тойрог замаар эргэдэг, ихэр гаригтай байсан аж. Гэвч лемур атлантчуудын өөр өөр бүлэглэлийн хоорондын сөргөлдөөн нь Дэлхийн тэнхлэгийг өөрчилсөн аймшигт дэлбэрэлтийг дагуулсан дайнаар төгсжээ. Үүнээс хойш ихэр гариг нь Дэлхий рүү ойртсоор байгааг хүмүүс анзаарч эхэлсэн байна. Уг гариг улам бүр ойртохоо Дэлхийн далай тэнгис эргээсээ халин гарч, урьд өмнө үзэгдэж байгаагүй хүчтэй шуург болжээ. Ингэхэд лемур-атлантчууд яаран сандран нисдэг төхөөрөмжиндөө сууж, тэнгэр хөөрөн дэлхийг үүрд орхихоор шийджээ. Ойртсоор буй гариг улам бүр бүр томорсоор төдөлгүй дэлхий уг гаригтай асар том гал үсэргэн мөргөлджээ. Ингэхэд хар үүлс нүүн цэвдэг хүйтэн болов. Ихэнх хүмүүс (атлантчууд) үхэцгээжээ. Үүнээс хойш Нар дорно

зүгээс гарч өрнө зүгт жаргадаг болов. Дэлхий өөр тойрог замд шилжин өөр нэгэн дагуул-Сартай болжээ.

Зарим эх сурвалхид дурдсанаар лемур-атлантчууд одоо хүртэл самадийн байдалд Хүний Генийн Сангийн төлөөлөгч болон оршсоор буй аж. Тэгвэл сурвалж бичгүүдэд “самади”, “хүний (хүн төрөлхтний) генийн сан” гэж юу юуг өгүүлдэг вэ? Самади гэдэг бол бурхан тэнгэрлэг хүмүү ариун гэгээн мэдрэмж, цэвэр сэтгэл бүхий, өөрөөр хэлбэл сөрөг чиглэлд эргэсэн торсын(сэтгэлийн энергийн) орноос ангижирсан байдгийнхаа ачаар гүн бясалгалд орж, өөрийгөө олон арван сая жилээр хүртэл өөрийгөө үхүүлэхгүй хадгалдаг чадвартай хүмүүс мөн. Гэгээнтнүүд, онцгой мэдрэмж, чадвар эзэмшсэн лам нарын өгүүлснээр лемурчууд, лемур-атлантчууд, атлантчууд гэсэн гурван үеийн ариун гэгээн хүмүүс газар дэлхийд гагц юулж, өөрийн иргэншлийн мөхөхийг гарцаагүйг мэдрэхлээрээ самадид орж, улмаар цүнсний хүчирхэг цэргүүдээр хамгаалуулан оршдог. Тэгээд тэд хэрэгцээтэй нөхцөлд Дэд оюуны тааллаар амь орж, шинэ хүн төрөлхтний иргэншлийг үүсгэх аж.

Тийнхүү самадидорсон хүмүүс л хүн төрөлхтний генийн санг бүрдүүлдэг. Гэхдээ хүн төрөлхтнийг шаардлагатай үед жинхэнэ аврах Генийн сан нь лемурчууд бөгөөд учир нь, тэд хамгийн хөгжилтэй хүмүүс мөн гэж эх сурвалжуудад мэдээлсэн байдаг. Э.Мулдашевийн номд: самадид байгаа хүн бол Нөгөө Ертөнц болон Дээд Оюун Ухаантай сүнсээрээ холбоотой байдаг. Бодитжих болон эс бодитжих үзэгдэл нь газар доорхи амьдралыг газар дэлхийдээр явуулахад хэрэгтэй байдаг аж хэмээн бичжээ.

Тэгвэл газар доорхи амьдрал гэж юу вэ? Газар доорхи амьдрал гэдэг бол юуны түрүүнд хүн төрөлхтний генийн сан юм. Түүний дүгнэлтээр газар доогуур газрын гадаргатай холбоогүй маш олон хөндий орон зай байдаг бололтой. Магадгүй ихэнх агуйн үүд хаалга он цагийн эхэнд нурж газарт орсон биз. Пирамидуудын доор орших газар доорх сүмүүд нь газрын гадаргууд гарцгүй юм. Тэгэхээр самадид буй хүн хэрхэн гарах хэрэг вэ? Бие махбодио эс бодитжуулан газрын гадаргууд гарсан хойноо дахин бодитжуулж буй болно гэсэн ганцхан хариулт буй юм. Өөрөөр хэлбэл тэд хоосон зүйлээс бий болж буй мэт үүсэх юм. Хүн төрөлхтний Генийн сан нь самадид буй янз бүрийн соёл иргэншлийн хүмүүсийг газрын гадаргууд гарцтай агуйнуудад хадгалаад зогсохгүй гарцгүй агуйнуудад бас хадгалда бололтой.

Манай иргэншлийн өмнө байсан атлантчуудын иргэншил нь аажимдаа лемур-атлантчуудын мэдлэгийг эзэмшин хөгжүүлснээрээ өндөр хөгжилтэй иргэншил болж чаджээ. Гэвч энэ иргэншлийн дотор дайнд хүргэсэн хагарал үүсчээ. Шинэ шинэ зэвсэг ашиглаж үргэлжилсэн дйн нь Атлантидыг мөхөлд хүргэжээ. Хожуу үеийн хар, шар хоёр арьстан атлантчууд эвс төгсгөлгүй дайн дажин дунд амьдарч, эцэстээ дэлхийн тэнхлэгийн тогтворт нөлөөлсөн хүчирхэг шинэ зэвсэг хэрэглэжээ. Дэлхийн бөмбөрцгийн тэнхлэг шилжсэнээр газрын гадаргууд өөрчлөлт орж, Атлантидын эх газрууд усанд автан живж, их үер болж, шинэ эх газрууд үүссэн байна.

Хар, шар атлантын хооронд болсон сүүлчийн шийдвэрлэх тулаан нь үер буух агшинд ховсын нөлөөн (телепацийн зэвсэг) дор байсан хар атлантчуудын мөхлөөр төгссөн гэнэ. Шар атлантчууд нисдэг төхөөрөмжөөрөө (вимана) гал усны Орон болох Гималай, Төвд болон Говьд нисэночиж амь гарчээ. Атлантидын эх газар бүгд живэн алга болжээ.

Атлантидын үед Хойд туйл нь Гималай, Төвд, Говийн элсэн цөл нутагт байсан аж. Тэнхлэг шилжих явцад Хойд Туйл одоогийн бүс рүү шилжжээ. “Хэт оюунтан”-уудын ивээлийг хүртсэн атлантчуудын нэгэн омог байж. Тэд нэгэн тэнгисийн гайхамшигт эрэг дээр амьдардаг байж. Их үерийн дараа тэдний нутаг дэвсгэр нь далайн түвшнээс дээш

хэдэн мянган тохой өндөрт өргөгдөж өндөр уулсаар хүрээлэгджээ. Энэ омгийн бөө, төлөгчид их үерийг зөгнөн хэлдэг байжээ. Тэгээд тэд түүх, дэлхийн газрын зураг, одон орон болон шинжлэх ухааны тэргүүлэгч ололт амжилтыг алтан самбарт буулган урьдчилан бэлджээ. Эдгээр алтан самбарыг багаж төхөөрөмж, ном судар болон бусад эд зүйлсийн дээжтэй цуг нэг нэгнээсээ алслагдсан чулуун агуйнуудад хийж ирээдүйн хүмүүст өөрсдийн түүхээ мэдүүлэх зорилгоор нуужээ. Энэ тэнгисийн ойролцоох хуурай газар өргөгдсөнөөс уур амьсгал өөрчлөгдөж ихэнх оршин суугчид нь цочир хүйтрэлээс болж үхэцгээн, амьд үлдсэн хэсэг нь өнөөгийн тэсвэр хатуужилт төвдчүүдийн өвөг дээдэс болжээ.

Тийнхүү манай дэлхийн өнөөгийн хүн төрөлхтөн бол шинжлэх ухааны ба философийн зарим төлөөлөгч тайлбарладагчлан мичнээс үүссэн биш, харин сөнөсөн иргэншлүүдийн амьд хоцорсон хүмүүсийн бууран доройтож, зэрлэгшсэн үүлдэр мөн. Яагаад сөнөсөн удмаасаа дордсон бэ? гэвэл өмнөх хоёр болон манай иргэншлийнхэн аль алинаас болсноор эх сурвалжуудад тайлбарлаж иржээ. Үүнд: лемурчүүд, атлантчууд аль алинд нь Дээд Оюун Ухаан буюу Бурхан тэнгэр их тусалж байв. Лемурын иргэншил бол хүн төрөлхтний үүсэл, мөхлийн шатан дахь хамгийн урт настай, хэдэн сая жил үргэлжилсэн мэдлэгийг шүтсэн, хамгийн өндөр хөгжилд хүрсэн байжээ.

Гэвч энэ иргэншилд мэдлэгийг тахин шүтэх нь аажимдаа эрх мэдлийг тахин шүтэх үзлээр солигдож эхэлжээ. Эрх мэдэлд хүрэхийн тулд мэдлэгийг ашиглаж эхэлсэн нь сайн сайхныг нураан, муу муухай бүхнийг үүсгэжээ. Зэвсэг үйлдвэрлэж, лемурчууд хэсэг бүлэг болон хуваагдаж, нэг нэгнээ сүрдүүлж эхлэв. Газар дэлхий дээр сөрөг энергийн бүрхүүл үүсэв. Лемурчуудын сайн сайхан үйлээс Ертөнцийн Мэдээллийн Оронд мэдлэг, эерэг энерги шингэх болжээ. Гэвч лемурчуудын өөр хоорондын дайсагналын уршгаар Нөгөө Ертөнцийн торсын (өөрөөр хэлбэл энерги зарцуулахгүйгээр мэдээлэл дамжуулдаг бөгөөд ямар ч хатуу биетийг нэвтрэх чадвартай байдаг) орныг нураах үйлчилгээтэй сөрөг сэтгэлийн энерги ч Ертөнцийн Мэдээллийн Оронд шингэж эхэлжээ. Хүн төрөлхтний түүхэн хөгжлийн явцад хуримтлагдан, Нөгөө Ертөнцийн торсын оронд шингэсэн газар дэлхий дээрх амьдралын талаарх бүх мэдээлэл устаж эхэлсэн аж.

Гай гамшиг тохиолдох нь гарцаагүйг ойлгосон ихэнх лемурчууд агуйд самадийн байдалд орцгоон, Хүн төрөлхтний Генийн санг үүсгэсэн байна. Хөгжингүй хэсэг лемурчууд бодитжих болон эс бодитжих үзэгдлийг ашиглан тоног төхөөрөмж, машин механизмаа аван газар доогуур орж Шамбалын болон Агартгийн орныг үүсгэснээр лемурын иргэншлийн технологийг хадгалах, хөгжүүлэх, Генийн санг хамгаалах боломжтой болжээ. Тэгээд сансрын гамшиг болж, үр дүнд нь газрын гадарга дээрх лемурчуудын иргэншил мөхжээ. Тийнхүү мэдлэг боловсролыг эрх мэдлээр сольсон нь иргэншлийн мөхөл бий болгосон аж. Гэвч аюул гамшиг учрахаас өмнө лемурын нийгэмд нуруугаар жижиг өөр төрхтэй хүүхэд төрж эхэлжээ. Эдгээр жижиг биетэй (3-5 метр) хүмүүсийн тоо улам бүр нэмэгдсээр байжээ. Тэд бол газар дэлхийн дараачийн иргэншил болох атлантчуудын эхний төлөөлөгчид аж. Тэдний нэг хэсэг нь лемурын их гамшигийг даван туулж цөөн хэдэн омог үүсгэжээ.

Лемурын иргэншил мөхсөний дараа атлантчууд арай гэж амьд үлдсэн байна. Учир нь “эх” лемур байхгүй ба дэлхий дээр амьдрах нөхцөл маш их хувьсан өөрчлөгджээ. Гамшигийн дараа үлдсэн атлантчуудаас цөөхөн хэд нь л оршихуйн хагас зэрлэг байдалд байгалийн жамаар шилжин амьдарсаар үлджээ. Атлантчууд нь лемурчуудын нэгэн адил хөгжил сайтай билгийн нүдтэй байсан учир Ертөнцийн Мэдээллийн Орны давтамжинд тааруулан лемурчуудын мэдлэгийг олж авах боломжтой байлаа. Гэвч торсын оронд

бичигдсэн лемурчуудын мэдлэг атлантчуудад яаран нээгдэхгүй байлаа. Тиймээс Атлантидын амьдралд хагас зэрлэг байдал харьцангуй удаан үргэлжилжээ.

Яагаад атлантчууд Ертөнцийн Мэдээллийн Орны мэдлэгийг ашиглаж чадахгүй байсан юм бол? Энэ талаар дараахь таамаглал хамгийн их жин дарж байна. Үүнд: Дээд Оюун Ухаан атлантчуудыг Ертөнцийн Мэдээллийн Орноос салгасан "SoHm"-ын "өөрөө боловсрогтун" гэсэн зарчмыг тэдэнд нэвтрүүлсэн байна. Яагаад гэвэл "SoHm"-ын зарчим нь зөвхөн манай соёл иргэншлийг тодорхойлогч шинж чанар бус, харин Нөгөө Ертөнцийн мэдээллийн орныг эвдэх оролдлогоос урьдчилан сэргийлэх Дээд Оюун Ухааны түгээмэл "зэвсэг" юм. "SoHm"-ын зарчмыг хэрэгжүүлсэн нөхцөлд хүн төрөлхтөн Нөгөө Ертөнцийн мэдлэггүйгээр өөрөө боловсорч "өөрөө өөртэйгээ" үлджээ. "SoHm"-ын зарчим нь юуны туруунд газар дэлхийн хамгийн өндөр хөгжсөн иргэншил болох лемурын соёл иргэншлийн цэцэглэлтийн үед олж авсан (торсын оронд бичигдсэн) мэдлэгийг хамгаалдаг. Зөвхөн Шамбалын болон Агарийн орнуудын хувьд л эдгээр мэдлэгүүд мөнхөд нээлттэй аж.

Эрх мэдлийг тахин шүтэх атлантчуудын үзэл нь Лемур гэгээнтнүүдийн хүчин чармайлтаар мэдлэг, сайн сайхан, хайр энэрлийг тахин шүтдэг үзлээр солигджээ. Ингэснээр атлантчуудын иргэншил хөгжил дэвшлийн замаар огцом өгсөж эхэлжээ. Тэгээд Телепати, таталцлын хүчинд сэтгэлийн энергиэр нөлөөлж, тарнийн хүч зэрэг нарийн ертөнцийн энергийг эзэмшив. Харцаараа хүнд юм зөөж, хот тосгон барьж, бие махбодио дотоод энергийн хүчээр эмчлэн эдгээж, тарнийн хүчээр агаарт хөвдөг болжээ. Аврага том хотууд барьж, тэнгэрт дахин хүчирхэг виманууд нисэлдэн, усан доор гайхамшигтай тариалангийн талбайнууд бий болж, аврага том хөшөө дурсгалууд сүндэрлэн боссон аж. Ертөнц хурц улаан өнгөтэй байлаа. Энэ үед мэдлэг, боловсрол, хайр энэрлийг тахин шүтэх нь атлантчуудын амьдралын үндсэн дүрэм нь байлаа.

Гэвч атлантчууд билгийн нүднийхээ тусламжтайгаар Ертөнцийн Мэдээллийн Орны давтамжинд тааруулан телепацийн аргаар өмнөх иргэншил болон лемурчуудийн мэдлэгийг хялбархан олж авч байсан тул мэдлэг боловсролыг дээдлэх үзэл бүрэн баталгаажихгүй байв. Атлантчуудын хүүхдүүд сургууль, их дээд сургуульд явах шаардлагагүй байсан гэнэ. Учир нь тархи хөгжихийн хирээр мэдлэг Ертөнцийн Мэдээллийн Орноос тархинд аяндаа орж байжээ. Гэвч атлантчууд аажимдаа мэдлэгийг биш, харин эрх мэдлийг тахин шүтэх үзэлтэй болжээ. Тэд хоорондоо байнга дайтдаг хэд хэдэн хэсэг бүлэг болон хуваагдсан байна. Хэзээ ч юм лемурчуудын олж авсан Нөгөө Ертөнцийн мэдлэгийг атлантчууд зэр зэвсэг бүтээхэд ашиглаж, эцэс төгсгөлгүй дайнд түүнээ хэрэглэх болсон аж. Тэгээд нөгөө Ертөнцийн торсын оронд их хэмжээний сөрөг энерги хуримталж, улмаар их гамшиг гарах нөхцөл бүрдсэн байна.

Их гамшиг болохыг мэдэрсэн атлантчууд Хүн төрөлхтний Генийн санд нэгдэн, агуйд самадид орцгоожээ. Хүн төрөлхтний Генийн сангийн үндсэн бүрдэл хэсэг нь ч атлантчууд болжээ. 850000 жилийн өмнө гай гамшиг тохиолдсон гэж гэгээнтнүүд бичсэн байдаг. Энэ гамшгаас болж дэлхийн тэнхлэг байрлалаа өөрчилж, туйлууд шилжин, дэлхийг бүхэлд нь хамарсан их үер болжээ. Гэсэн ч их үерт атлантын соёл иргэншил шууд мөхсөнгүй. Тэдний нэг хэсэг нь (шар атлантчууд) агаарын хөлөг онгоцондоо (вимана) суун Гималай, Төвд, Говийн бүс рүү, буюу их үерээс өмнө Хойд туйл байсан дэлхийн бөмбөрцгийн өндөрлөг бүс нутаг руу нисэж амжсан гэнэ. Говийн элсэн цөлийн буйран дээр байсан Дотоод Тэнгэсийн эрэг, арлууд дээр тэд суурьшин дахин хэдэн арван мянган жилийг өнгөрүүлжээ. Гэвч хүн амын дутмагшил, тусгаарлагдсан байдал, хамгийн гол нь

Ертөнцийн Мэдээллийн орны мэдлэг болох “шидэт саваа” үгүй болсон (“SoHm”-ын зарчим нэвтэрсэн) нь нийгмийн доройтол, зэрлэгшил, мөхөлд хүргэсэн байна.

Атлантчуудын нөгөө хэсэг нь (хар атлантчууд) африк тивийн өндөрлөг газрууд дээр амьд үлджээ. Гэвч тэд мөн дээрх шалтгаанаар маш хурдан зэрлэгшин мөхөлд хүрсэн ажээ. Эдгээр хар атлант өнөөгийн хар арьстан бүрэлдэн бий болоход зохих хувь нэмэр оруулсан гэсэн таамаг байдаг. Атлантын далайд оршдог Платоны арал дээр атлантчуудын гурав дахь хэсэг нь амь гарчээ. Энэ хэсэг атлантчууд илүү хөгжингүй байв. Тэд “SoHm”-ын зарчмын улмаас Ертөнцийн Мэдээллийн оронтой харьцах боломжгүй болсон нөхцөлд ч мэдлэг ухаанаа алдалгүй эрдэм шинжилгээний судалгаа хийн технологио хөгжүүлж Нөгөө Ертөнцийн шууд нөлөөгүйгээр хүмүүсээ сэтгэл оюуны хөгжилд хүргэж чаджээ. Платоны арлын атлантчууд газар дэлхийн шинэ нөхцөл байдалд тогтворжин 850000 жилийн өмнөөс 11000 жилийн өмнөх үе хүртэл урт удаан хугацаанд амьдарсан байна.

Энэ хугацаанд их үерийн үеэр Дэлхийн гадарга дээр тогтсон их ус татарч, хуурай газар томорч, уг шинээр үүсэн бий болж буй эх газар, арлууд дээр тав дахь иргэншлийн хүмүүс буюу манай иргэншлийнхэн үүсчээ. Тэднийг эх сурвалжуудад “аричууд” гэж нэрлэдэг. Эдгээр шинэ хүмүүс атлантчуудын хувьд маш жижигхэн, тэнэг бас уурхай мэт санагддаг байжээ. Платоны арлын атлантчууд эдгээр шинэ хүмүүсийн заримтай нь байлдаж, заримтай нь эв найрамдалтайгаар харьцдаг байсан байна. Жишээ нь Платоны арлын атлантчууд эртний египетчүүдтэй маш ойр дотно харьцаж, тэдэнд мэдлэг технологио дамжуулан, хүнд зүйлсийг таталцлын хүчинд сэтгэлийн энергиэр үйлчлэн зөөвөрлөж, египетийн пирамидуудыг хамтран бүтээжээ. Пирамидуудыг 75-80 мянган жилийн өмнө барьсан. Пирамидуудыг барьж дууссаны дараа атлантчуудын ихэнхи нь, мөн зарим нэгэн египетүүд пирамидуудын доорх оромжинд гүн самадид орж, Хүн төрөлхтний Генийн санг нэмэгдүүлжээ. 11000 жилийн тэртээ Платоны арлын атлантчуудын одон орон судлаачид Тифоны солир удахгүй дэлхий дээр унахыг мэджээ. Солир ойртсоор Атлантын далайд унав. Атлантчуудын сүүлийн тив болсон Платоны арал далайн давалгаанд живэн оджээ. Ингэж атлантчуудын иргэншил бүрмөсөн мөхсөн байна.

Атлантын иргэншлийн хэвлийд ойролцоогоор 1 сая жилийн өмнө үүссэн аричууд жижигхэн биетэй, том хамартай, сарьсан таславчгүй том хөлтэй байв. Тэд хуурай газрын амьдралд илүү дасан зохицсон байсан учраас атлантчуудыг бодвол давуу талтай байжээ. Эдгээр ер бусын гадаад төрхтэй хүмүүс ажиллах чадвар сайтай, маш идэвхтэй байсан боловч сэтгэл оюуны хувьд, ялангуяа сэтгэлийн энергийн үйлчлэл үзүүлэх талаараа атлантчуудаас хавьгүй сул дорой байж. Гэсэн ч тэдний сэтгэл оюуны хөгжил нь өнөөгийн хүнийнхээс хавьгүй дээр байжээ. Анхны аричууд нь өөрсдийн эцэг өвгөд болох атлантчуудаас нарийн ертөнцийн энергийн зарим төрлийг эзэмшиж самадид орж телепати, телекинезийн үйлчлэл үзүүлж сурчээ.

Анхны аричууд 2-3 метрийн өндөртэй, орчин үеийн хүмүүстэй харьцуулбал авраг хүмүүс байсан ч атлантчуудын хувьд жижигхэн биетэй санагддаг байжээ. Анхны аричууд үүссэн атлантчуудын иргэншлийн сүүлийн шатанд “SoHm”-ын зарчим хэрэгждэггүй байсан. Тиймээс тэдгээр аричууд нь атлантчуудын нэгэн адил Нөгөө Ертөнцийн мэдлэгийг ашиглах боломжтой байжээ. Анхны ари хүүхдүүд мөн л тархиныхаа хөгжлийн хирээр Ертөнцийн Мэдээллийн орноос мэдээлэл хүлээн авдаг, сургуульд явах шаардлагагүй байжээ. Анхны аричуудын “билгийн нүд” орчин үеийн хүнийхээс илүү хөгжилтэй атлантчуудынхаас үйл ажиллагааны хувьд дутмаг байжээ. Тэд атлантчуудыг бодвол илүү бодитжсон, газрын амьдралд дасан зохицсон хүн байлаа. Анхны аричуудын үүсэл ца хугацааны хувьд атлантчууд хоорондоо эрх мэдлээ булаалцалдан сөргөлдөж, дайта

тулалдаж байсан үе шаттай таарчээ. Анхны аричууд эрх мэдлийг тахин шүтэх үзлийг атлантчуудаас уламжлан авсан нь өнөөг хүртэл бидний арийн иргэншилд хадгалагдсаар. Атлантчуудын хамтаар анхны аричууд омог хоорондын дайнд оролцдог байжээ. Тэд атлантаас илүү тэсвэр тэвчээртэй бүдүүн баараг байв.

Атлантчууд ч мөн дэлхийн гамшиг ойртож буйг мэдэж байсан боловч эрх мэдлийг тахин шүтэх үзэл нь дийлжээ. Дэлхийн гамшиг болохын өмнөхөн аричуудын ихэнх нь гүн самадид орж Хүн төрөлхтний Генийн сангийн аричуудын хэсэг нь голчлон эдгээр анхны аричуудаас тогтсон байна. Тэд "SoHm"-ын зарчим хэрэгжээгүй байхад амьдарч байсан учир Нөгөө Ертөнцийн үндсэн мэдлэгийг эзэмшсэн байж, зарим нэг нь сэтгэлийн энергийн үйлчлэлийг (амилуулах, өвчнийг анагаах гэх мэт) мөн үзүүлж чаддаг байжээ. Бидэнтэй адил төстэй гадаад төрхтэй Гэгээнтнүүд (Моисей, Мухаммед, Есүс Христос гэх мэт) бол их үерийн өмнө гүн самадид орсон анхны аричууд юм. Анхны аричууд Шамбал, Агартгийн орны талаар мэддэг, тэдэнд мөргөдөг, лемурчуудыг "Бурхан тэнгэрийн Хүү" хэмээн шүтэцгээдэг гэж эртний судар ба гэгээнтнүүдийн бүтээлд бичсэн байдаг. Мөн тэдгээрт бичснээр анхны аричууд самадид Хүн төрөлхтний Генийн санг дүүргэх гэж бус, харин агуйд уг гамшгийг өнгөрүүлэх зорилготой ордог байжээ.

Их үерийн үеэр (850000 жилийн тэртээ) ихэнх ари нь атлантчуудын нэгэн адил амь үрэгдсэн аж. Хуурай газрын ил үлдсэн багахан хэсгүүд дээр л цөөн хэдэн атлантчууд болон аричууд амь гарцгаажээ. Энэ бол байр байшин, технологи, тоног төхөөрөмж бүгд үгүй болсон хүнд хэцүү цаг үе юм. Гэвч "SoHm"-ын зарчим нэвтэрч, хүмүүс Нөгөө Ертөнцийн мэдлэгээс тусгаарлагдсан нь л хамгийн хэцүү зүйл байлаа. Зэрлэгшсэнээс болж амьдрал анхдагч хэлбэрт шилжжээ. Ийм нөхцөлд амьд үлдсэн аричууд атлантчуудтай байнга дайтаж байлаа. Тэд их үерийн дараа ил гарч ирж буй хуурай газруудад суурьшин, хот тосгон барьж байлаа. Харин атлантчууд тусгаарлагдсан омог үүсгэн амьдарч, хүн ам цөөн, цус ойртсон гэрлэлтээс болоод аажмаар мөхөцгөөж байжээ.

Их үерийн дараа маш удаан хугацааны туршид газар дэлхий жижиг жижиг чулуурхаг арлуудаас бүтэж байсан тул хашигдмал байдал, цус ойртсон гэрлэлт нь аричуудын удамшлын үзүүлэлтийг муутгажээ. Үүний улмаас арийн нийгэм хэдэн зуун мянган жилийн турш хөгжсөнгүй. Энэ үед хүн төрөлхтний Генийн сангаас цөөнгүй Хутагт Гэгээнтнүүд (Будда нар) гарч ирсэн боловч тэдний үйл ажиллагаа амжилт олсонгүй. Учир нь арийн нийгмийн доройтох үйл явц илүү хүчтэй байсан бололтой. Аричуудын бие жижгэрэн 1.5 орчим метр болж тэд улам бүр зэрлэг омгийн төрхтэй болж байлаа.

Э.Мулдашевийн таамгаар 100-200 мянган жилийн тэртээ газар дэлхий дээр Төвд, Африкийн өмнөд хэсэг, Газрын дундад тэнгисийн бус нутагт тархсан аричуудын гурван үндсэн бүлэг байсан бололтой. Эхний хоёр бүлэг нь яваандаа бүрэн доройтож зэрлэгшин, зөвхөн Газрын дундад тэнгисийн бүлэг л хөгжсөн нь эртний Египетийн иргэншлийг үүсгэжээ. Эртний египетийн иргэншил бүрэлдэн тогтоход зөвхөн Гэгээнтнүүд ч бус мөн Платоны арлын атлантчуудтай ойр дотно харилцаатай байсан нь нөлөөлсөн бололтой. Египетийн иргэншил хөгжлийн өндөр түвшинд хүрчээ. Египетийн пирамид нь тэдний атлантчуудтай хамтарсан хөдөлмөрийн үр бүтээл бололтой. Хэзээ, яагаад египетийн иргэншил мөхсөн бэ? гэдгийг шинжлэх ухаан тогтоож чадаагүй байна. Эртний египетчүүд Тифоны солир дэлхийг, мөргөсний уршгийг мөхсөн Платоны арлын атлантчуудын адил бас амссан бололтой гэж судлаачид үздэг.

18000-аас цаашхи жилийн өмнө Төвд Гималайн нутагт нэгэн шинэ Хутагт Гэгээнтэн бий болжээ. Зарим нь түүнийг Ману, зарим нь Рама, зарим нь Бумба Будда гэдэг байжээ. Энэ хүн аврага биетэй, ер бусын дүр төрхтэй байжээ. Чухам түүний нүдийг л

Төвдийн бүх сүм дээр дүрсэлсэн юм шиг байна гэж Э.Мулдашев бичжээ. Энэ нүдийг шинжлэхэд лемур хүний нүд байсан аж. Тийм бол хүн төрөлхтний Генийн сангаас Хутагт Гэгээнтэн болж лемур хүн өөрөө гарч ирсэн байх нь.

Арийн иргэншил оршин тогтнож буй Их Үерээс хойшхи энэ бүх хугацаанд Хүн төрөлхтний Генийн сангаас зөвхөн атлантчууд, эртний аричууд л гарч ирж байсан бөгөөд тэдний дунд лемур байсангүй гэж гэгээнтнүүдийн болон судлаачдын бүтээлд тэмдэглэсэн байдаг. 18000 жилийн тэртээх үед хүн төрөлхтөн зэрлэг, хагас зэрлэг омгуудаас тогтож, хөгжих найдвар улам бүр багассаар байлаа. Зөвхөн египетийн иргэншил энэ бүгдээс ялгарч байсан боловч мөн л доройтлын шинж тэмдэг илэрч байжээ. Арийн иргэншилд болж буй үйл явцыг Шамбалын болон Агартгийн орон судлан эцэстээ лемур хүнийг Гэгээнтэн болгон илгээхээр шийджээ. Ингээд 18013 жилийн өмнө дэлхий дээр Бумба Будда заларчээ. Тэрээр Төвдийн бүс нутагт байхдаа юуны түрүүнд аричуудаас эрэгтэй эмэгтэй хүмүүсийг шилэн авч тэднийг хагас зэрлэг омгийнхоос тусгаарлаж, яаж амьдрахыг зааж сурган, үржиж олшрох, дэлхийн бөмбөрцгөөр тархахад нь нөлөөлж байлаа. Чухам эдгээр хүмүүс бол “статистикийн дундаж нүд”-тэй (төвд үндэстэн) юм. Эдгээр хүмүүс л дэлхийн бөмбөрцгөөр тархан хагас зэрлэг омгийнхныг шахан зайлуулж, харин үлдэж хоцорсон хагас зэрлэг омгууд нь (офтальмогеометрийн бүдүүвчинд багтаагүй) одоог хүртэл хагас зэрлэг хэвээр үлдсэн хэрэг. Лемур Гэгээнтнүүдээр ном заалгасан эдгээр хүмүүс л аажмаар хөгжиж эхэлсэн байна.

Ингэж хөгжсөн хүмүүс хагас зэрлэг омгуудтай хийсэн газар нутгийн төлөөх тэмцэлдээ тэднийг (хагас зэрлэг аричуудыг) шахан зайлуулжээ. Зарим нутагт тэд хагас зэрлэг хүмүүстэй холилдсон боловч зарим нутагт үндэстний цэвэр байдлаа хадгалж, оршин буй газар нутгийнхаа нөхцөл байдлын дагуу гадаад төрх нь өөрчлөгджээ. Зарим хагас зэрлэг омог бөглүү алслагдсан газар нутаг болох Амазонк, Африкийн ширэнгэн ой, номхон далайн бүс нутгийн зарим арлууд зэрэгт үлдэж хоцорсон бололтой. Гэсэн ч офтальмогеометрийн баримтуудаас үзвэл Төвдөөс гаралтай арийн зарим бүлэглэл ч гэсэн зэрлэгшсэн (Өмнөд Америк, Полинезийн арлууд зэрэг) аж. Гэлээ ч Төвдөөс гаралтай аричууд манай иргэншлийг хөгжлийн замд аажимхан боловч хөтөлсөн юм. Лемур Гэгээнтэн ари үндэстний доройтох явцыг тасалж чадсан учир тэрээр хүмүүсийн ой санаанд үүрд үлдэж, харин түүний нүд хөгжлийн бэлгэ тэмдэг болон төвд сүм бүрийн чимдэг аж. “Хүн мичнээс үүсээгүй” гэж үндэслэдэг орчин үеийн нэг үзэл болох Э.Мульдашевийн оккультив шинжлэх ухааны үзлийн агуулгыг илэрхийлэхэд ийм байна.

Бас өөр олон зохиогч оккультив, спиритуалист, эзотерик мэдлэгийг шинжлэх ухааны мэдлэгтэй холбон тайлбарлах замаар хүний үүслийн тухай бичиж иржээ. Жишээ нь, оросын зохиогч И.Г.Катюхин байгалийн нууц үзэгдэл, үлэг гүрвэл, сөнөсөн иргэншлийн ул мөр, үл таних нисдэг биет зэргийн талаар цуглуулсан баримт сэлтдээ тулгуурлаад: 10 мянган жилийн тэртээ Фазтон гаригийн хүн ам хүчилтөрөгч дутагдан аюулд орж, үүний улмаас өөрсдөө гаригаа зориуд устган, дэлхийд нүүн ирсэн бөгөөд тийнхүү орчин үеийн хүн бол харь гаригаас нүүн ирэгсдийн үр сад мөн гэж дүгнэсэн байдаг¹. Чухам яаж нүүн ирсэн тухай дараах зүйлийг И.Г.Катюхин өгүүлсэн байдаг. Үүнд Фазтон гаригийн эрдэмтэд маш боловсронгуй бөгөөд хүчирхэг техник ашиглах үндсэн дээр Бархасбадаас сонгосон дагуулаар төрөлх гаригаа бутлахад янз бүрийн чулуулаг, хөрс ус манай дэлхий дээр бууж; чулуулаг хөрс манай дэлхийг бүрхэн; дэлхийн хэмжээ ба жин нэмэгдэж; тэнхлэгийнх нь эргэлт удааширсан үр дагавар гарсан байна. Ийнхүү Фазтоноо нүүн ирсэн хүн, амьтан, ургамал үндсэндээ төрөлх гаригийнхаа нөхцөлд ойролцоо

¹ Энэ тухай: Иван Катюхин. Соёл иргэншлийн үүсэл. Бид хэн бэ? Бид хаанаас ирсэн бэ? УБ., 2009 номноос үзнэ үү.

нөхцөлд амьдрах болсон байна. Гэвч тэрхүү өөр гаригаас дэлхийн хүнд нөхцөлд нүүн ирсэн хүмүүсийн өндөр хөгжилт иргэншил аваас чулуун зэвсгийн бүдүүлэг хүмүүсийн зохион байгуулалт хүртлээ бууран доройтсон ажээ.

Хүний үүслийг өөр гаригийн өндөр хөгжсөн иргэншлийн шалтгаантайгаар тайлбарладаг үзлийг аргазүйн хувьд зөвтгөдөг тийм шинжлэх ухааны таамаглалыг өрнөдийн зарим судлаач дэвшүүлж ирсэн байна. Тийм таамаглалын үүднээс хандвал өндөр хөгжилтэй өөр соёл иргэншлийнхэн манай дэлхийг оршин суугчидтай болгох зорилгоор амьдрал үүсгэж чадах бичил биетүүдийг дэлхийд маань өөрсдийн элчээрээ дамжуулан “халдааснаар” манай гаригт амьдрал үүссэн аж¹. Оккультив, эзотерик янз бүрийн үзэлд манай сэдэвт хамаарах зарим нийтлэг дүгнэлт байдаг. Үүнд, нэгдүгээрт орчин үеийн хүн бол Ч.Дарвины онолд сурталчилдаг хувьслын замаар бий болсон биш, харин сөнөсөн ертөнцийн өндөр иргэншилт хүмүүсээс үүсэлтэй. Хоёрдугаарт, тэрхүү өндөр хөгжилт хүн нь байгаль, цаг уурын гоц хүндрэлтэй нөхцөлд улам бүр бууран доройтож зэрлэгшсэний улмаас хүй нэгдлийн нийгмийн хүмүүс болтлоо, зарим нь бүр хүн дүрст мич болтлоо бууран доройтсон аж.

Энэ мэтээр танин мэдэхүйн эрэл хайгуулын хүрээнд хүний үүслийн талаар янз бүрийн үзэл, онол зэрэгцэж болон өрсөлдөн оршиж байна. Хэдийгээр Ч.Дарвины хувьслын онолыг няцаах дайралтыг шинжлэх ухааны олон төлөөлөгч явуулж байгаа боловч уг онолыг хамгаалдаг байр суурь хадгалагдсаар байгаа юм. Нэг жишээ дурдъя. “Үнэн” сонины 2010 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн дугаарт бичсэнээр Өмнөд Африкаас энэ улсын эрдэмтэн Ли Бергер ойролцоогоор 2 сая жилийн тэртээ амьдарч байсан хүүхдийн бүтнээрээ шахам яс олсон нь бараг сармагчиных шиг, гэхдээ бас орчин үеийн хүнийхтэй адилхан байсан гэнэ. Энэ олдвороос зарим хүн Ч.Дарвины хувьслын онол баттай нотлогдлоо гэсэн дүгнэлт хийсэн аж. Гэвч тийм дүгнэлтийг баттай үнэн гэх аргагүй юм. Учир нь, уг олдворыг оккультив шинжлэх ухааны дүгнэлтийн, өөрөөр хэлбэл орчин үеийн хүн үүссэн нь сөнөсөн атлантын иргэншлийн өндөр хөгжилтэй хүн манай дэлхийд тэсэн үлдэж, ингэхдээ улам бүр зэрлэгшсэний үр дүнд хүн дүрс бич (гоминид), улмаар зарим нь сармагчин болж хувирсан гэдэг үзлийн үндэслэгээ болж бас чадахаар юм.

Хүний үүслийн шалтгааны тухай шинжлэх ухааны, оккультив шинжлэх ухааны, спиритуалист зэрэг янз бүрийн үзлийн төлөөлөгчид энэ талаархи өөр өөрийнхөө тайлбарыг үнэн хэмээн нотлох зорилт тавьдаг нь мэдээж юм. Гэтэл угтаа тэдгээрийн алиныг нь ч гэсэн үнэн юм уу худлаа хэмээн эрс зарлах байдал философи арга зүйн хувьд утгагүй байдаг. Учир нь, тэдгээр үзлийн аль нь ч танин мэдэхүйн хөгжлийн өнөөгийн түвшинд хэрэг дээрээ баттай үнэн биш байж, харин тэдгээрийг зохиогчийн болон тэрхүү зохиогчийг дэмжигчийн мэдлэг болж байдаг. Үүний улмаас тийм хязгаарлагдмал хүрээнд үнэнд тооцогддог уг мэдлэг нь бусад олон олон сонирхогч хүн ба субъектэд нууцлаг мэдлэг мөн.

Гурав. Хүний үүслийн тухай оккультив шинжлэх ухаан, спиритуалист мэдлэг зэргийн агуулгад үнэний хувь ямар байх ёстой тухай трансценденталист үзлийн онцлог. Философийн олон чиглэлийн үүднээс хандвал онолын мэдлэгийн (шинжлэх ухаан, шашин, урлагийн онол, ёс зүйн сургаал, философи зэрэг) аль ч төрөл үнэнийг ганцаараа өмчлөх үндэсгүй байдаг билээ. Ийм үнэлэмж хүний үүслийн тухай янз бүрийн төрлийн онолын мэдлэгт, түүний дотор бидний дээр авч үзсэн мэдлэгт бас хамаарна гэж бид үзэж байна. Арга зүйн ийм зарчим бүхий үнэлэмжийг трансценденцийн тухай К.Ясперсийн философи баримтлал бас илэрхийлдгийг энд онцлон авч үзье.

¹ Энэ тухай дурдсан нэг бүтээл: Ж.Пүрэвсүрэн, Н.Түгжсүрэн. Уудам орчлон, ухаант амьдрал. УБ, 1987

Транценденцийн тухай К.Ясперсийн философи баримтлал нь ахуй гэж юу болох түүний ямар ямар төрөл байдаг тухай тэрээр хэрхэн ойлгосонтой нь уялддаг байна. Түүний хувьд ахуйн гурван үндсэн төрөл буюу талбар байдаг. Үүнд: 1). Ертөнц-дэх-ахуй. Энэ бол ерийн оршихуй буюу юман оршихуй мөн. Юман оршихуй бол хүнийг субъект-объектийн харилцаа, өөрөөр хэлбэл хүнийг юм гэж үздэг харилцаа мөн. Ахуйн тийм түвшинд оршдог хүнийг К.Ясперс "Dasien" гэж нэрлэжээ (гэтэл экзистенциализмын өөр нэг төлөөлөгч М.Хайдеггерийн хувьд "Dasien" бол Би-гийн ахуйн "энэ", "энд", "одоо" зэрэг агшинг илэрхийлж, өөрөөр хэлбэл жинхэнэ ахуйг илэрхийлж, харин К.Ясперсийн "Dasien" гэдэг категорийг "экзистенци" гэж нэрлэдэг билээ). 2). Экзистенци (К.Ясперсийн энэ ойлголт бол М.Хайдеггерийн "Dasien" гэж нэрлэсэн категори мөн). К.Ясперс ахуйн энэхүү хоёр дахь төрлийг онцолсон бөгөөд энэ нь хүн бол юм төдий биш, харин хамгийн гол нь бодгаль, бие хүн гэж тэрээр үздэгээс нь үүдэлтэй байдаг.

К.Ясперсийн тайлбараар экзистенци бол эрх чөлөөт хүсэл эрмэлзлийн ертөнц мөн. Гэхдээ энэхүү ертөнц нь тэр бүр хүн анзаардаггүй. Үүнд: бид өдөр тутмын амьдралынхаа нөхцөлд юмс ба хүмүүст оршихуйн түвшинд л харьцдаг. Гэтэл хүн энэхүү юман ертөнцөөсөө тасрах агшинтай тулгардаг бөгөөд энэ агшин бол ирмэгийн нөхцөл мөн. Ирмэгийн нөхцөл бол хүн ахуйн бусад талбартай нүүр тулгарч, улмаар экзистенци нь хурт илэрдэг тийм нөхцөл мөн. Энэ нөхцөл бол тухайн би сэтгэлийнхээ (гэмших, цухалдах, ичих, айх зэрэг) илрэл (модус)-тэй тулгарах үед бүрддэг. 3). Трансценденци. К.Ясперсийн "трансценденци" гэдэг философи баримтлал дараах байдлаар үндэслэгддэг. Үүнд экзистенци бол гагцхүү өөр экзистенцтэй харьцаж байж оршдог. Өөрөөр хэлбэл экзистенци бол ганцаараа, өөрийнхөө төлөө оршдог биш (энэ нь экзистенцийн тухай М.Хайдеггер, Ж.П.Сартр нарын тайлбараас өөр байдаг). Тиймээс өөрийгөө танихуй бол хамаарал (коммуникаци)-аас салангид хэрэгждэггүй (ийм тайлбар францын католик шашны экзистенциалист Г.Марсельд бас байдаг). Чухамхүү хамааралын нөхцөлд ахуйн хоёр дахь төрөл болох экзистенци илэрч, нөгөө талаар ахуйн энэхүү төрөл байдгаа хамаарал бололцоотой байдаг.

К.Ясперсийн үзлээр хамаарал нь экзистенциас гадна бас трансценденци байдгийг хүчээр оршдог. Хамаарлын явцад экзистенци нэгдмэл рүү чиглэж, хүнийг үл давтагдагч бодгаль, бие хүн болгож байдаг. Гэхдээ жинхэнэ нэгдмэл бол трансценденци мөн. Ахуйн гурав дахь төрөл (талбар) болох трансценденци нь ертөнц-дэх-ахуй, экзистенци хоёрыг хоёуланг нь өөртөө нэгтгэдэг. Экзистенци нь трансценденцигүй бол хүсэхийн аргагү шуламсын зөрүүд авир мөн.

Тийнхүү К.Ясперсийн тайлбараар экзистенци трансценденцитэй харьцах байдал нь бишрэлийн үйлдэлд хэрэгждэг. Гэхдээ тэрээр шашны бишрэл, философийн бишрэл хоё ялгаатай гэж тайлбарласан байдаг. Үүнд, түүний үзлээр хүн транценденцийг яг байгаагаа нь сэтгэж чаддаггүй бөгөөд харин зөвхөн өөртөө ойлгомжтой юмны түвшинд илэрхийлдэг. Тиймээс трансценденцийн талаарх тухайн хүний мэдлэг бол нэгэн төрөл нууц түлхүүр буюу шифр мөн. Тийм шифрүүд нь бишрэлийн экзистенциаль үйлдлийг бүтээл болж байдаг. Уг бүтээл нь шашны бишрэлийн бүтээлээс ялгаатай. Яагаад гэвэл шашны бишрэл нь янз бүрийн нууц түлхүүрийг бэлгэдэл (символ) болгож үүгээрээ тэдгээр бэлгэдлийг юм болгон хувиргаж, өөрөөр хэлбэл трансценденцийг өөртөө-байгаа ахуйн түвшинд буулгадаг. Харин философийн (тодорхой хэлбэл экзистенциаль бишрэлийн үүднээс хандвал трансценденцийг юм болгон хувиргаж болохгүй бөгөө түүний (трансценденцийн) талаарх бидний сэтгэлгээ нь зарим нэг нууц түлхүүр зохиодог. Мөн К.Ясперсийн тайлбараар шашны бишрэл нь Бурхан тэнгэрийг объект болго

илэрхийлж ингэснээрээ тэр (шашны бишрэл) нь үнэн (жинхэнэ) бишрэл байж үл чадан, гагцхүү мэдлэг болж хувирдаг.

К.Ясперс ийм үзлийнхээ үүднээс Библид мэдээлдэг дээд нээгдэл (revelation-откровение)-ийг шүүмжилсэн. Учир нь, түүний тайлбараар дээд нээгдэл бол хэн нэг нь өөр нэгэнд илэрч буй дээд нээгдэл мөн бөгөөд тийм болбоос субъект-объектын харилцаа үүсэж, өөрөөр хэлбэл трансценденци болох Бурхан тэнгэрийг хүнд эсрэг бол гэж байдаг. Үүний улмаас дээд нээгдэл хүнд хэрэгжихэд түүнд бишрэл биш, харин мэдлэг өгөгддөг. Угтаа бишрэл мэдлэг хоёр холбоогүй. Өөрөөр хэлбэл бишрэл бол миний эзэмдэж буй мэдлэг биш, харин намайг залж буй бат итгэл болж байдаг. Гэхдээ К.Ясперс шашны тодорхой үнэ цэнийг үгүйсгээгүй бөгөөд ер нь түүнийг экзистенциализм дахь христос шашны жигүүрийн нэг том төлөөлөгч гэж олон судлаач үнэлж иржээ. Шашин үнэнээрээ байхын тулд хэрсүү философийг түшдэг, философи өгөөжтэйгөөрөө байхын тулд шашны мөн чанарыг түшдэг байх ёстой хэмээн тэрээр бичсэн байдаг.

Трансценденцийн тухай, түүнийг хүн танин мэддэг биш, зөвхөн өөрийнхөөрөө ойлгодог тухай К.Ясперсийн философидолтын үүднээс хандвал хүний үүслийн асуудлаарх шинжлэх ухааны болон шинжлэх ухааны биш аливаа онол, бясалгал баттай үнэн байдаггүй. Учир нь, энэ асуудлаарх шинжлэх ухааны, оккульттив шинжлэх ухааны, спиритуалист зэрэг янз бүрийн үзлийн төлөөлөгчид өөр өөрийнхөө тайлбарыг үнэн хэмээн нотлох зорилт тавьдаг нь мэдээж юм. Гэтэл угтаа тэдгээрийн алиныг нь ч гэсэн үнэн юм уу худлаа хэмээн эрс зарлах байдал философи арга зүйн хувьд утгагүй байдаг. Учир нь, тэдгээр үзлийн аль нь ч танин мэдэхүйн хөгжлийн өнөөгийн түвшинд хэрэг дээрээ баттай үнэн биш байж, харин тэдгээрийг зохиогчийн болон тэрхүү зохиогчийг дэмжигчийн мэдлэг болж байдаг. Үүний улмаас тийм хязгаарлагдмал хүрээнд үнэнд тооцогддог уг мэдлэг нь бусад олон олон сонирхогч хүн буюу субъектийн хувьд (К.Ясперсийн философи нэр томъёог ашиглавал) нууц буюу трансценденци мөн.

Ишлэл авсан бүтээлүүд

1. К.Ясперс. Духовная ситуация времени. М., 2004. Пятая часть.
2. Г.Армаа. Хүний үүсэл. I. Дэлхий дахин. УБ., 2008
3. Иваң Катюхин. Соёл иргэншлийн үүсэл. Бид хэн бэ? Хаанаас ирсэн бэ?. М., 2009
4. Э.Мулдашев. Хүн мичнээс үүсээгүй. Орчуулсан М.Пүрэвжав. УБ., 2005
5. Ж.Пүрэвсүрэн, Н.Түгжсүрэн. Уудам орчлон, ухаант амьдрал. УБ., 1987
6. Пьер Тейяр де Шарден. Феномен человека. М., 1987